

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 24 өдөр

Дугаар 01

Хархорин сум

*Компанийн 2020 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлантай холбогдуулан
ТУЗ-аас гаргасан дүгнэлтүүдийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.
2. Компанийн 2020 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 24 өдөр

Дугаар 02

Хархорин сум

*Ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай*

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/2020 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компани нь 2020 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дагуу нийт 294,144 мянган төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласантай холбогдуулан 2021 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 24 өдөр

Дугаар 03

Хархорин сум

*Компанийн үйл ажиллагаанд шаардагдах
санхүүжилтийн тухай*

“Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан олгогдож байгаа ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээл болон хөдөө аж ахуйн салбарт хаврын тариалалтын үйл ажиллагааг дэмжсэн хөнгөлөлттэй зээлийг авч “Хархорин” ХК-ийн болон түүний охин компаниудын үйл ажиллагаанд зарцуулахаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоолын нэгд заасан хөнгөлөлттэй зээл авах, тухайн зээлийн ерөнхий нөхцөлүүдтэй уялдуулан зээлийн хугацаа, хүүний хэмжээг тогтоох, зээлийн барьцаанд “Хархорин” ХК-ийн болон түүний охин компаниудын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө, газар эзэмших эрхийг барьцаалах зөвшөөрлийг гүйцэтгэх удирдлагад олгох, үүнтэй холбоотой тогтоол шийдвэрийг гаргах бүрэн эрхийг “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
3. Тогтоолын нэгд заасан зээлийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороонд даалгасугай.
4. Тогтоолын нэгд заасан зээлийн зарцуулалтын тайланг 2022 онд хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



П.УЧРАЛ

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр сарын 24 өдөр

Дугаар 04

Хархорин сум

*Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүдийг томилох тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-г удирдлага болгон “Хархорин” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр

- ✓ Сандагийн Амгалан
- ✓ Баатарын Амарсанаа
- ✓ Баттулгын Бүрэн нарыг үргэлжлүүлэн томилсугай.

2. “Хархорин” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр

- ✓ Пүрэвийн Бишрэл
- ✓ Жаргалын Энхтөр
- ✓ Цэрэндолгорын Энх-Амгалан
- ✓ Пүрэвийн Учрал
- ✓ Ойдовсүрэнгийн Төмөрбаатар
- ✓ Лхагвасүрэнгийн Хосбаяр нарыг үргэлжлүүлэн томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



И.УЧРАЛ